



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРОО



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ
ГАЗАР

Статистикийн тойм:

“Гэр бүлийн хүчирхийлэл”



Улаанбаатар
2020 он

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ТООН МЭДЭЭЛЭЛ

Дэлхийн түвшинд¹

Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний эрхийн хамгийн том зөрчлийн нэг төдийгүй үүний хохирогч нь дийлэнхдээ хүүхэд, эмэгтэйчүүд болдог. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Байгууллагын мэдээлснээр дэлхий дээр өмнөх 12 сарын хугацаанд 15-49 насны 243 сая охид, эмэгтэйчүүд нөхөр, хамтрагчийн зүгээс бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн байна.

Энэ талын мэдээлэл дутмаг, далд хэлбэртэй байдгаас гэр бүлийн болон бусад төрлийн хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авахад бэрхшээлтэй тулгардаг, тухайлбал, хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдийн 40 хүрэхгүй хувь нь аливаа төрлийн тусламж хүсдэгээс 10 хүрэхгүй хувь нь цагдаад ханддаг байна.

Түүнчлэн 4 улсын 1 нь эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийлээс тусгайлан хамгаалах хуультайгаас харахад ихэнх улс оронд хууль эмэгтэйчүүдийн талд байдаггүйг харуулж байна.

Дэлхий даяар тархаад буй COVID 19 шинэ халдвараас сэргийлэхийн тулд улс орнууд тусгаарлах, хөл хорионы арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаатай зэрэгцэн гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэх нь өсөж, тусламж үйлчилгээний хэрэгцээ нэмэгджээ. Учир нь хүчирхийлэл үйлдэгчтэй хүүхэд, эмэгтэйчүүдийг тусгаарлах байдлыг нэмэгдүүлж, тэдэнд

тусалж чадах хүмүүс, боломжоос нь мөн холдуулж байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас тусламжийн утасны үйлчилгээ, хоргодох байраар хангах хэрэгцээ нэмэгдэж байгаа талаар Аргентин, Канад, Франц, Герман, Испани, Нэгдсэн Вант Улс, АНУ-ын засгийн газрын эрх баригчид, эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгчид, иргэний нийгмийн байгууллагууд тайландаа тэмдэглэсэн байна.

Хөл хорио, тусгаарлалт нь аюулгүй байдал, эрүүл мэнд, мөнгөний түгшүүрээс үүдэлтэй хурцадмал байдлыг өдөөдөг. Тиймээс энэ арга нь хаалттай хаалгааны цаадах хүчирхийлэгчдийг хянах боломжийг сулруулж байна.

Үүнээс гадна COVID халдварын тархалтын улмаас эрүүл мэндийн байгууллагын яаралтай бэлэн байдлыг хангахад түр хоргодуулах байрыг нэмэлтээр ашиглах нь энэ чиглэлийн үйлчилгээ авах боломж, хүртээмжийг бууруулж байна гэжээ.

¹ <https://www.unwomen.org/en/news/stories/2020/4/statement-ed-phumzile-violence-against-women-during-pandemic?fbclid=IwAR3rq5vkv8IOJLQIPpWKdtV91nlzXl-U33Ek6Y8jXDV4UKW81oPtZ-1Jcw>

МУ-ын гэр бүлийн хүчирхийллийн тоон мэдээллийн эх үүсвэрүүд

Монгол Улс 2016 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлан, 2017 оноос эхлэн мөрдөж байгаагаас гадна Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт энэ чиглэлийн асуудлыг тусган өгч, хэрэгжүүлж байгаа. Түүнчлэн хүчирхийлэлд өртсөн иргэдэд тусламж, зөвлөгөө өгөх, хамгаалах байраар хангах зэрэг үйлчилгээ үзүүлж байна. Тухайлбал, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр байгуулсан хохирогчдод үйлчилгээ үзүүлэх 15 нэг цэгийн үйлчилгээний төвөөс гадна дэмжлэг үзүүлэн хамгаалах 2 байр тогтмол үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсын хувьд гэр бүлийн хүчирхийллийн тухай тоон мэдээллийг гаргахад Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргийн мэдээ болон тусгайлсан түүвэр судалгаа гэсэн 2 гол эх үүсвэрийг ашиглаж байна.

Тусгайлсан судалгааны хувьд хэдийгээр энэ чиглэлийн төрийн бус байгууллагуудын хийсэн судалгаа байдаг хэдий ч Үндэсний Статистикийн Хорооноос 2017 онд улсын хэмжээний “Жендэрт суурилсан хүчирхийллийн түүвэр судалгаа”-г анх удаа зохион байгуулсан. Тус судалгаа нь ОУ-ын арга зүйд нийцсэн, өөрийн орны онцлогийг тусган эмэгтэйчүүдийн нөхцөл байдлыг гаргасан юм.

Судалгааны дүнгээр МУ-д гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа түршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна. Гэр бүлийн хүрээнд тухайлбал, нөхөр/хамтрагчийн зүгээс 10 эмэгтэйн 6 нь (57.9%) амьдралынхаа түршид хүчирхийлэлд өртсөн. Эдгээр эмэгтэйчүүдийн 4 хүн тутмын 1 нь (26.5%) хэн нэгэнд хандаж, хэлж байгаагүй байна.


Цагдаагийн ерөнхий газарт гэмт хэрэг болон зөрчлийн гэсэн 2 төрлийн бүртгэлээс гэр бүлийн хүчирхийллийн талаарх тоон мэдээлэл гардаг.

Энэхүү танилцуулгаар дээрх 2 эх үүсвэрийн 2019, 2020 оны 1 дүгээр улирлын мэдээллийг ашиглан гэр бүлийн хүчирхийллийн хандлага, байдал ямар байгааг товчхон харуулахыг зорилоо.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН УЛМААС ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

Улсын хэмжээнд 2020 оны эхний 3 сард 8003 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1902(19.2%)-оор, гэр бүлийнхүчирхийллийнүлмаас үйлдэгдсэн **279** гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 104 (27.2%)-өөр тус тус буурчээ. Тус гэмт хэргийн нийт дүнд эзлэх хувь 3.5 байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурсан байна.

Зураг 1. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, 1-р улирлын байдлаар, сонгосон оноор



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэрэг 2019 оны эхний улиралд өдөрт дунджаар 4 удаа байсан бол 2020 оны эхний улиралд 3 болж буурсныг харуулж байна.


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн **279** гэмт хэргийн

- 91.0% (254) нь хөнгөн, 9% (25) нь хүнд ангилалтай,
- 48.1% нь Улаанбаатар, 51.9% нь орон нутагт,
- 41.9% (117) нь согтуугаар,
- 8.2% (23) нь эмэгтэй хүнээр,
- 86.4% (241) нь гэр орон сууцанд үйлдэгжээ.

Мөн 10 хэрэг тутмын

- 5 нь мягмар, пүрэв, ням гарагт,
- 6 нь оройн 19 цагаас өглөөний 6 цагийн хооронд болжээ.

Зураг 2. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэргийн тоо, цаг, гарагаар, 2020 оны 1 дүгээр




Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэгт **273** иргэн, үүнээс 238(87.2%) эмэгтэйчүүд, 30 (11.0%) хүүхэд өртөж, хохирсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 43 (18.7%)-аар, үүнээс хүүхэд 16 (2.1 дахин)-аар, эмэгтэй хүн 25 (11.7%)-аар тус тус өсжээ. Өртөж хохирсон иргэдийн 40.2 хувь нь ажилгүй, 59.8 хувь нь ажил эрхэлдэг байна. Мөн тус гэмт хэрэгт ихэнхдээ эхнэр/нөхөр, хамтран амьдрагч (77.3 хувь) өртөж, хохирчээ.

Хүснэгт 1. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэгт өртсөн, хохирсон иргэдийн тоо, хамаарлаар

Хамаарал	2019.III	2020.III
БҮГД	230	273
Үүнээс:		
<i>эхнэр</i>	118	150
<i>нөхөр</i>	20	10
<i>хамтран амьдрагч</i>	54	51
<i>хүүхэд</i>	3	21
<i>бусад</i>	35	41

Энэ төрлийн гэмт хэрэгт өртөж хохирсон 10 эмэгтэй тутмын 6 нь 25-39 насныхан байгаа бол 10 эрэгтэй тутмын 5 нь хүүхэд (0-17 нас) болон хөгшид (50, түүнээс дээш нас) байна.

Зураг 3. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэгт өртсөн, хохирсон иргэдийн тоо, насны бүлэг, хүйсээр, 2020 оны 1-р улирлын байдлаар



Тус гэмт хэргийн улмаас 185.9 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирч, өмнөх оны мөн үеэс 35.2 сая (23.4%) төгрөгөөр өссөн байна.


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэгт 2020 оны эхний 3 сард **259** хүн сэжигтнээр тооцогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үеэс 36.3 (69) хувиар өссөн байна. Эдгээр шалгагдсан иргэдийн 61.8 (160) хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, 48.4 хувь ажилгүй, 51.6 хувь нь ажил эрхэлдэг байна. Мөн шалгагдсан иргэдийн 95.8 хувь боловсролтой, үүнээс 46.7 хувь нь бүрэн дунд, 20.8 хувь нь дээд, 17.0 хувь нь суурь боловсролтой байна.

Хүснэгт 2. Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт шалгагдсан иргэдийн тоо, боловсролын байдлаар

Боловсролын байдал	2019.III	2020.III
БҮГД	375	259
Боловсролгүй	5	11
Боловсролтой	185	248
<i>Бага</i>	18	23
<i>Суурь</i>	31	44
<i>Бүрэнд дунд</i>	100	121
<i>Тусгай мэргэжлийн</i>	9	6
<i>Дээд</i>	27	54


Энэ төрлийн гэмт хэрэгт шалгагдсан 10 эрэгтэй тутмын 6 нь 25-39 насныхан байгаа бол 10 эмэгтэй тутмын 6 нь 18-34 насныхан байна.

Зураг 4. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэгт холбогдон шалгагдсан иргэдийн тоо, насны бүлэг, хүйсээр, 2020 оны 1-р улирлын байдлаар



ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИАР ШИЙДВЭРЛЭСЭН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ТООН МЭДЭЭ

Цагдаагийн байгууллагад 2020 оны эхний 3 сард 545.9 мянган зөрчил бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас 3131 зөрчил шалган, 2244 зөрчлийг шийдвэрлэжээ. Өмнөх оны мөн үеэс нийт зөрчил 15.0 (71.1 мянга) хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүдсэн зөрчил 61.6 (1193) хувиар, үүнээс шийдвэрлэсэн нь 99.3(1118) хувиар тус тус өсжээ.




Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчилд 1813 иргэн өртөж, хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 72.8 (764) хувиар өссөн байна. Тэдний 92.7 (1681) хувь нь эмэгтэйчүүд байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүдсэн зөрчил 2019 оны эхний улиралд өдөрт дунджаар 21 удаа бүртгэгдэж байсан бол 2020 оны эхний улиралд 34 болж өссөнийг харуулж байна.

Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүдсэн **3131** зөрчлийн:

- 72.6% нь нийслэлд, 27.4% нь орон нутагт,
- Зөрчлийн хуулийн “5.4.4.1 зодсон;” зүйлийг зөрчсөн нь 76.6%, “5.4.4.2 хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан” зүйлийнх 18.1%, бусад холбогдох зүйлийнх 5.3%,
- 94.2% нь гэр, орон сууцанд, 5.8% нь бусад газарт,
- 10 зөрчлийн ойролцоогоор 7 нь шөнө оройн 19-24 цагийн хооронд гарчээ.

Зураг 6. Бүртгэгдсэн зөрчил, цагаар




Шийдвэрлэсэн 2244 зөрчлөөс 50 иргэнийг 6.3 сая төгрөгөөр торгох, 2194 иргэнийг баривчлах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс торгосон шийтгэл 28 (2.3 дахин)-аар, баривчилсан шийтгэл 1090 (98.7%) хувиар тус тус өссөн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүдэн гарч, шийдвэрлэгдсэн **2244** зөрчлийн:

- 2186 (97.4%) эрэгтэйчүүд, 58 (2.6%) нь эмэгтэйчүүд холбогдсон,
- Холбогдон, шалгагдсан 10 хүн тутмын 6 нь 30-44 насныхан,
- Холбогдон, шалгагдсан иргэдийн 74.2% нь нөхөр, хамтран амьдрагч бүхий хамааралтай,
- 10 хүн тутмын 8 нь суурь болон бүрэн дунд боловсролтой байна.

Зураг 7. Шийдвэрлэгдсэн зөрчил, дүнд эзлэх хувиар, холбогдогчийн насны бүлгээр



АЛБАДАН ЭРҮҮЛЖҮҮЛЭГДСЭН ИРГЭДИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ


Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн санд бүртгэгдсэнээр албадан эрүүлжүүлсэн хүмүүс (давхардсан тоогоор) 2020 оны эхний 3 сарын байдлаар 27.0 мянга болж өмнөх оны мөн үеэс 6.0 (1743) хувиар буурчээ.

Эндээс нэг хоногт эрүүлжүүлсэн тохиолдлыг тооцвол, 300 болж өмнөх оны мөн үеэс 14-өөр буурсан байна.

Албадан эрүүлжүүлэгдсэн **27.0 мянган** хүний:


- 91.6% нь эрэгтэйчүүд, 8.4% нь эмэгтэйчүүд,
- 92.3% нь дунд, 6.9% нь хүнд, 0.8% нь хөнгөн зэргийн соглолттой,
- 76.9% нь бусдын тайван байдлыг алдагдуулсан, 11.9% нь согтуу үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, 3.0% нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, 5.5% нь хаана байгаага мэдэхгүй болон гэмт хэрэгт өртөж болзошгүй гэсэн шалтгаантай,
- 86.9% нь эрхэлсэн ажилгүй, 13.1% нь ажилтай,
- 91.8% нь суурь болон бүрэн дунд, 3.9% нь дээд, 1.3% тусгай/техникийн, 1.2% нь бага боловсролтой, 1.8% нь боловсролгүй байна.

Зураг 8. Эрүүлжүүлэгдсэн иргэд, дүнд эзлэх хувиар, саатуулагдсан цагаар



- Эрүүлжүүлэгдсэн 10 хүн тутмын 8 нь өдрийн 16 цагаас шөнийн 4 цаг хүртэлх хугацаанд саатуулагдсан,
- 74.5% нь Улаанбаатарт, 25.5% нь орон нутагт ногдож байна.

Зураг 9. Эрүүлжүүлэгдсэн хүн амын тоо, байршлаар, 2020 оны 1-р улирлын байдлаар



ДҮГНЭЛТ

Улсын хэмжээнд 2020 оны эхний 3 сард 8003 гэмт хэрэг бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 279 гэмт хэрэг байгаа нь өмнөх оны мөн үеэс 27.2 хувиар буурчээ. Тус төрлийн гэмт хэрэгт 273 иргэн өртөж, хохирсон байгаа нь өмнөх оны мөн үеэс 18.7 хувиар өсжээ.

Нэг цэгийн үйлчилгээний төвд 2020 оны эхний 3 сарын байдлаар, нийт 920 хүн үйлчлүүлсэн (618 нь эмэгтэй, 114 эрэгтэй, 274 хүүхэд) нь өмнөх оны мөн үеэс 76.6 хувиар нэмэгдсэн байна.

2020 оны эхний 3 сард 545.9 мянган зөрчил бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас 3131 зөрчил шалган, 2244 зөрчлийг шийдвэрлэжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал, нийт зөрчил 15.0 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүдсэн зөрчил 61.6 хувиар тус тус өсжээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо буурсан хэдий ч үүний улмаас гарсан хохирол нэмэгдсэн, нөгөө талаас энэ төрлийн зөрчлийн тоо нэмэгдэж байгаа нь анхаарал хандуулах асуудал болохыг харуулж байна. Учир нь гэр бүлийн хүчирхийлэл нь далд явагдахын зэрэгцээ, давтагддаг, давтагдах бүрдээ шинж чанарын хувьд улам ноцтой болдог өвөрмөц шинж бүхий үйл явц юм. Нөгөөтээгүүр нийтийг хамарсан цар тахал дэгдсэн энэ цаг үед олон нийтийн дунд бухимдал стрессийн түвшин нэмэгдсэний улмаас гэр бүлийн хүчирхийлэл өсөх зүй тогтол манай улсад ч мөн илэрч байна.

Дээрх нөхцөл байдлыг үндэслэн дүгнэхэд зөрчил гаргасан тохиолдлыг дахин давтагдуулахгүй байх талаас нь үе шаттай, уялдаатай, олон талын оролцоог хангах, богино хугацаанд үр ашигтай байх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал,

- Утас болон онлайнаар сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг эрчимжүүлэх.
- Олон нийтийн мэдээллийн эх үүсвэр ашиглан өрх гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, харилцааг дэмжих, стресс бууруулах арга замуудыг сурталчлах, эерэг хандлага нэмэгдүүлэх ажлыг нэмэгдүүлэх.
- Эрэгтэйчүүдийн зан үйл, амьдралын зөв хэв маягийг таниулах, сурталчлах, зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах.
- Ахуйн хүрээний архидалт (ГБХ-ийн гэмт хэргийн 91.8%, зөрчлийн 94.2% нь гэр, орон сууцад гарсан) -ыг бууруулахад согтууруулах ундаа борлуулах цэг, цагийн хуваарьт хязгаарлалт хийх, үнийг татвараар зохицуулах.
- Өрх, гэр бүлийн эдийн засгийн дарамтыг багасгах арга хэмжээг эрчимжүүлэх.

Эдгээр арга хэмжээг авахад төрийн байгууллагаас гадна төрийн бус байгууллагын идэвхтэй үүрэг, оролцоо чухал гэдгийг онцлон дурдаж байна.

